



ЭЭРЭГ НӨЛӨӨ БҮТЭЭСЭН 2024 ОН





Эрхэм зорилго

Лоринэт Сан нь Монгол Улсад туслалцаа дэмжлэг шаардлагатай байгаа хүүхэд, залуус, айл өрхүүдийн амьдралд тогтвортой, эерэг өөрчлөлтийг бий болгох үндсэн зорилготой.

Нийгмийн үр нөлөө

Бид дараах байдлаар нийгмийн үр нөлөөг бий болгохыг зорин ажилладаг. Үүнд:

- Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсрол болон Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэнээр гарах **ШУУД ҮР НӨЛӨӨ**
- Мэдлэг, мэдээллийг боловсруулан түгээж, олон талт хамтын ажиллагааг бэхжүүлж, урт хугацааны үр өгөөж бүхий сайн туршлагуудыг тогтолцоонд нэвтрүүлснээр бий болгох **СИСТЕМИЙН ТҮВШНИЙ ҮР НӨЛӨӨ**

Дэмжлэг үзүүлж буй чиглэлүүд

- **БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН АСАРГАА ХАЛАМЖ, БОЛОВСРОЛ**
Бага насны хүүхдүүд асран халамжлуулах, насны онцлогтоо тохирсон эрт үеийн боловсрол эзэмших боломжийг бий болгох.
- **ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**
Залуучууд тогтвортой хөдөлмөр эрхлэх, орлого болон амьдралын чанараа сайжруулах боломжийг бий болгох.

Дэмжлэг үзүүлж буй аргачлал

Лоринэт Сан нь Монгол Улсад нийгмийн үр нөлөөг бодитоор авчирч байгаа шинэлэг төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудад санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх замаар нийгмийн эерэг нөлөөллийг бий болгодог.

2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2024 он бидний хувьд **“Сайн Туршлагаа Тогтолцоонд Нэвтрүүлэх”** стратегийг ахиулсан онцлог жил байлаа.

Төсөл хөтөлбөрүүдийн цар хүрээг тэлсэн нь

- Бид нийгмийн хөрөнгө оруулалтаа улам бэхжүүлж үр нөлөө бүхий төсөл хөтөлбөрүүд болох **Уанскайн “Илүү сайхан ирээдүйг бүтээх нь”**, **Азийн сангийн “Хамтдаа уншицгаая”**, **Зориг сангийн “Залуусын тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”** зэргийн цар хүрээг тэлж хамтын ажиллагааг үргэлжлүүллээ. Мөн **Кристина Ноблийн Хүүхдийн Сангийн** эрсдэлт бүлгийн залуусын боловсрол, нөхөн сэргээх замналыг бэхжүүлэхэд чиглэсэн **“Өсвөр насныхны хөгжлийн хөтөлбөр”**-өөр дамжуулан шинэ түншлэл эхлүүллээ.
- Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт нь хүүхэд, залууст нөлөөлөх өргөн хүрээний асуудал хэмээн үзэж **Дэ Нэйче Консерванси** байгууллагын **“Өнө мөнхийн Монгол”** санаачилгад хөрөнгө оруулснаар орон нутгийн тогтвортой хөгжил, байгаль хамгааллыг дэмжин ажиллалаа.

Экосистем бэхжүүлсэн нь

НҮБ-ийн Хүүхдийн Сантай хамтран **Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээг** удирдан ажиллахын зэрэгцээ энэхүү сүлжээг мэдлэг солилцох, хамтын ажиллагааны идэвхтэй платформ болгон хөгжүүлэхэд хувь нэмрээ орууллаа.

2024 онд бидний манлайлал үндэсний болон олон улсын түвшинд өндрөөр үнэлэгдэв:

- **Үндэсний залуучуудын чуулган** болон **Монголын эдийн засгийн форум**-д уригдаж, залуучуудыг дэмжих үр дүнтэй арга замуудыг танилцуулав.
- **Сасакава Пийс Сангийн** (Sasakawa Peace Foundation) **“Triple Ripple”** тайланд бидний филантропи салбар дахь манлайллыг дурдаж Ази бүсийн онцлох тоглогчдын нэгээр тодотгов.
- Биднийг **Олон Улсын Боловсролын Санхүүжүүлэгчдийн Бүлэг** (International Education Funders Group) болон **Хөрөнгийн Удирдлагын Институт** (Wealth Management Institute)-аас урьж, үр өгөөж бүхий нийгмийн хөрөнгө оруулалтын талаар туршлагаа хуваалцах боломжийг олгов.



2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

Эерэг үр нөлөөг нэмэгдүүлсэн нь

Бид нийгмийн үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд **нэмэлт хөрөнгө татан төвлөрүүлэх стратеги** боловсруулж, олон улсад Монголыг сурталчлан таниулахыг зорилоо.

Голлох амжилтууд:

- **Сингапур, Монгол хоорондох хандивын урсгалыг** нэмэгдүүлэх түншлэлийг эхлүүлэв.
- **Швейцар болон Сингапур улсад** Монголын нийгмийн тулгамдаж буй асуудлуудыг танилцуулах арга хэмжээ зохион байгуулав.
- Бизнесийн салбарын оролцоог нэмэгдүүлэхээр **Монгол дахь Америкийн Худалдааны Танхимтай** хамтран Улаанбаатар хотын гэр суурьшлын бүсэд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг танилцуулах өдөрлөг зохион байгуулав.
- **Эйшиа Филантропик Вэнчурс** (Asia Philanthropic Ventures)-ээс зохион байгуулсан туршлага судлах айлчлалд дэмжлэг үзүүлж Монголын нийгэмд тулгамдаж буй голлох асуудлуудыг танилцуулав.

Баг, хамт олон

- Бид **Удирдах Зөвлөлөө тэлж шинэ гишүүн Тьерри Дэпанафү** (Thierry de Panafieu)-ийн үнэ цэнтэй зөвлөгөө, чиглүүлгээр сангийн удирдлага, манлайллыг бэхжүүллээ.
- Түүнчлэн **Хөтөлбөрийн менежерээр Бат-Өлзийн Эрдэнэсүвд** нэгдэж сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг улам сайжруулах боломжийг бүрдүүллээ.

2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



2024 онд төсөл хөтөлбөрийн шууд үр шим
хүртэгчдийн тоо:

2,310 бага насны
хүүхдүүд

671 эцэг эх, асран
хамгаалагчид

105 залуучууд

214 бага насны хүүхдийн
асаргаа халамж, эрт
үеийн боловсролын
үйлчилгээ үзүүлэгчид

Төсөл хөтөлбөрийн тойм

2024 онд бидний санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрүүд туршилтын шатнаас дараагийн шатанд ахиж амжилттайгаар цар хүрээгээ тэлсэн онцлог жил байсныг дурдах нь зүйтэй. Төсөл хөтөлбөр тус бүр шийдлүүдээ бататгаж, хэмжигдэхүйц үр дүнг үзүүлэн, тогтолцооны гол тоглогчид тэр дундаа төрийн байгууллагуудад өндрөөр үнэлэгдэж экосистемийн түвшинд эрчээ авч чадсан байна.

Эдгээр төсөл хөтөлбөрүүд Лоринэт сангийн эерэг үр нөлөөтэй, цар хүрээгээ тэлэх боломжтой, тогтвортой шийдлүүдэд санхүүжилт олгох үзэл баримтлалтай ямагт нийцэж байдаг. Бид аливаа саад бэрхшээлийг даван туулж, урт хугацааны өөрчлөлт авчрах нэгдмэл алсын хараатай хамтрагч байгууллагуудтай үнэ цэн, итгэлцэлд суурилсан түншлэлийг бий болгож чадсандаа бахархалтай байна.



Бага насны хүүхдийг асарч халамжлах ур чадварыг нэмэгдүүлэх нь



Хэрэгжүүлэгч байгууллага
Уанскай
2020 оноос хойш

Уанскайн “Илүү сайхан ирээдүйг бүтээх нь” хөтөлбөр нь эцэг эх, асран хамгаалагч нарын бага насны хүүхдэд асаргаа халамж үзүүлэх ур чадварыг нэмэгдүүлэх зорилготой.

Хөтөлбөрийн туршилтын үед (2020-23) Улаанбаатар хотын гэр суурьшлын бүсийн 1,729 асран хамгаалагч, үйлчилгээ үзүүлэгчдийг чадавхжуулж 5,700 гаруй хүүхдийн сайн сайхан байдлыг дээшлүүлсэн байна. **2024 онд уг хөтөлбөр тэлэлтийн үе шатанд орж** илүү олон хүүхдэд чанартай асаргаа, эрт үеийн боловсрол олгох зорилгоор цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгчид, асрамжийн газруудад үйл ажиллагаагаа өргөжүүлж байна.

Онцлох үйл явдал:

2024 онд Уанскай гэр бүлийг чадавхжуулах сургалтаа үргэлжлүүлэн **513 асран хамгаалагч, 1,247 хүүхдэд** хүрч ажиллав. Түүнчлэн гэр суурьшлын бүсэд хомс байдаг хүүхдэд зориулсан аюулгүй нийтийн орон зайн асуудлыг шийдвэрлэхээр **Хүүхэд хөгжлийн тоглоомын төвийн** нээлтийг хийлээ. Энэхүү төв нь бүтэн жилийн турш нээлттэй ажиллах анхны Монгол гэр доторх тоглоомын төв гэдгээрээ онцлог юм. Мөн сургалт болон бусад нөөцөөр дутмаг байдаг хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан чадавхжуулах хөтөлбөрийг эхлүүлэв. Ингэснээр хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгчдийн чадавх болоод үйлчилгээний чанарыг сайжруулах ач холбогдолтой.

Уанскай нь **бодлогын орчинд сайн туршлага судлах боломжийг нээх зорилгоор** холбогдох төрийн албан хаагчдыг БНХАУ руу өөрсдийн хэрэгжүүлж буй асрамжийн газар, асралт гэр бүлийн хөтөлбөртэй танилцуулах айлчлалыг зохион байгуулж, Монголд нутагшуулан хэрэгжүүлэх боломжийг судлалаа.

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН АСАРГАА ХАЛАМЖ, БОЛОВСРОЛ



Номоор дамжуулан эрт үеийн боловсролыг дэмжих нь



Хэрэгжүүлэгч байгууллага
Азийн сан
2021 оноос хойш

Азийн сангийн “Хамтдаа Уншицгаая” хөтөлбөр нь бага насны хүүхдэдтэй хамтдаа ном унших дадлыг эцэг эх, асран хамгаалагчдад сурталчилж, номоор дамжуулж бага насны хүүхдийн эрт үеийн боловсрол болон хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой.

Төслийн туршилтын үед (2021-24) бага насны хүүхдэд ном уншихын ач холбогдлыг сурталчлах нөлөөллийн аян, эцэг эх асран хамгаалагчдад үр дүнтэй унших арга техникийг үлгэрлэн харуулах уншлагын арга хэмжээ, Монгол хэл дээрх чанартай хүүхдийн номын хүртээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөр зэрэг цогц арга замаар **1,464 эцэг эх, асран хамгаалагчид болон 3,412 хүүхдэд** хүрч ажилласан байна. Үүн дээр тулгуурлан 2024 оноос төслийн хүрээнд амжилттай хэрэгжсэн үлгэрийн цаг, хүүхдийн ном бүтээх феллоушип хөтөлбөр, уншлагын өдөрлөг зэрэг үйл ажиллагааг үргэлжлүүлэхийн зэрэгцээ **төрийн бодлого, сургалтын хөтөлбөрт хувь нэмрээ оруулахад анхаарч ажиллаж байна.**

Онцлох үйл явдал:

2024 онд төслийн хүрээнд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтран сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрт чанга уншлагын аргачлалыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэв. Энэхүү санаачилга нь одоогоор улсын хэмжээнд 18 цэцэрлэгт туршигдаж, ирэх хичээлийн жилээс орон даяар хэрэгжих ба **Монгол Улсын сургуулийн өмнөх боловсролын тогтолцоонд үр дүнтэй уншлагын аргыг нэвтрүүлэх томоохон алхам** болж байна.

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН АСАРГАА ХАЛАМЖ, БОЛОВСРОЛ



АМЖИЛТЫН ТҮҮХ

Дагинаагийн түүх: Асаргаа халамж хүүхдийн хөгжилд нөлөөлөх нь

Гурван настай Дагинаа* гэр бүлийнхээ хамт Улаанбаатар хотын захын дүүрэгт амьдардаг. Гэр суурьшлын бүсэд дэд бүтэц, чанартай үйлчилгээ хязгаарлагдмал тул нэн ялангуяа бага насны хүүхдэд хөгжих боломжоор хомс байдаг.

Дагинаагийн гэр бүл бусдын л адил сайн сайхан амьдрах боломжийг эрэлхийлж Улаанбаатарт суурьшихаар шилжин ирсэн боловч амьдралын нөхцөл, өрхийн амьжиргаанаас шалтгаалж хүүхдэдээ анхаарч, чанартай асаргаа халамж үзүүлэхэд хүндрэлтэй тулгардаг байв.

“Би Уанскайн сургалтаас өмнө охиддоо уурлаж, тэд асуулт асуух, хамт тоглохыг хүсэх үед бухимддаг байсан” хэмээн Дагинаагийн ээж Жагаа хэлэв.



Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдэдээ асаргаа халамж үзүүлэх арга барилыг заадаг гэр бүлийн чадавхжуулах сургалтад хамрагдсанаар Жагаа охидтойгоо илүү сайн харилцдаг болж тэдний гэрт өөрчлөлтийг авчирчээ. "Одоо Дагинаа надтай илүү нээлттэй харилцдаг болсон. Тэр өөрийн бодол, мэдрэмжээ айж эмээлгүй илэрхийлж, бүр эгч дүү нартайгаа ч илүү их хуваалцдаг болсон. Миний сурсан зүйл манай гэр бүлийн амьдралыг бүхэлд нь өөрчилсөн" гэж тэрээр хуваалцав.

Сургалтаа төгссөний дараа ч Жагаа хүүхдүүдийнхээ хамт Уанскайн Гэр бүлийн төв болон Хүүхэд хөгжлийн тоглоомын төвд тогтмол зочилдог болжээ. "Гэрийн ажил хэзээ ч дуусахгүй. Харин энд ирэх нь бидний хувьд баяр хөөртэй амралтын цаг" гэж тэр хэлэв. "Энд ирснээр надтай адил бусад ээжүүдтэй уулзаж, ярилцаж, хүүхдүүд маань хамт тоглодог. Гэртээ харихдаа бид инээд хөөр, шинэлэг санаагаар дүүрсэн байдаг. Яагаад ч юм, манай гэр одоо тийм ч жижигхэн санагдахгүй болсон."

**Хувь хүний мэдээллийг нууцлах үүднээс нэрийг өөрчилсөн болно. Энэхүү түүхийг хамтрагч байгууллага Уанскай хуваалцав.*

Залуучуудыг боловсролоос хөдөлмөр эрхлэлтэд дэмжих нь



Хэрэгжүүлэгч байгууллага
Зориг сан
2018 оноос хойш

Зориг сангийн “Залуусын тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” нь их, дээд сургууль төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээлд шилжих шилжилтийг дэмжсэнээр залуусын ажилгүйдлийн түвшнийг бууруулах зорилготой.

2018 онд 100 гаруй залуусыг хөдөлмөр эрхлэх ур чадвар, ажлын туршлагаар хангах зорилготой хэрэгжиж эхэлсэн туршилтын хөтөлбөр нь одоо Монголын дээд боловсролын тогтолцоонд нэвтэрч дараагийн шатандаа өргөжиж байна. **2024 оноос хөтөлбөрийн цар хүрээг тэлж, их сургуулиудын карьер хөгжлийн үйлчилгээг бэхжүүлж**, ажил олгогч нартай түншлэлийг өргөжүүлж, цаашлаад карьер үйлчилгээг дээд боловсролын тогтолцоонд нэвтрүүлэхээр зорьж байна. Хөтөлбөрийн хүрээнд 2,000 залууст карьерын дэмжлэг авах, 8,000 залууст мэдлэг, ойлголт нэмэгдүүлэх боломжийг олгож хамгийн багадаа 10,000 залууст хүрч ажиллах юм.

Онцлох үйл явдал:

2024 онд Зориг сан Монголын ууган төрийн өмчит их сургууль болох **Монгол Улсын Их Сургуультай (МУИС) хамтран карьер хөгжлийн цогц үйлчилгээний тогтолцоо** бий болгохоор ажиллаж байна. Үүний хүрээнд МУИС-ийн Карьер хөгжлийн төвийн төлөвлөгөөг боловсруулж, Карьер Клубийг амжилттай нээсэн нь урт хугацааны тогтвортой байдлыг хангах эхний алхам боллоо. Энэхүү санаачилга нь цаашлаад бусад их, дээд сургуулиудад хэрэгжүүлэх боломжтой карьер үйлчилгээний загвар хөтөлбөрийг бий болгох эхлэл болж буйгаар онцлог юм.

ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



Эрсдэлт бүлгийн залуусыг нийгэмд амжилттай эргэн нэгтгэх нь

ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



Хэрэгжүүлэгч байгууллага
Кристина Ноблийн Хүүхдийн
Сан: 2024 оноос хойш

“Өсвөр насныхны хөгжлийн хөтөлбөр” нь Монголын шүүх тогтолцооны томоохон орон зайг нөхөж сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад сурч, хүмүүжиж буй өсвөр насныханд цогц дэмжлэг үзүүлэх зорилготой.

2024 онд Кристина Ноблийн Хүүхдийн Сангаас (КНХС) сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад буй **14-19 насныхныг нийгэмд амжилттай эргэн нэгтгэх цогц үйлчилгээний загварыг** хэрэгжүүлж эхэллээ. Энэхүү хөтөлбөр нь өсвөр насныхныг боловсрол, ур чадвараар ханган, тэдэнд шинэ боломж, итгэл найдварыг бий болгож, улмаар Монгол Улсад давтан гэмт хэргийн түвшнийг бууруулахад хувь нэмрээ оруулах юм. Түүнчлэн, гэр бүл, олон нийтийг татан оролцуулснаар ялгаварлан гадуурхлыг арилгаж, өсвөр насныхныг нийгэмд эргэн нэгдэхэд дэмжлэг болох зорилготой.

Онцлох үйл явдал:

2024 онд хөтөлбөрийн хүрээнд өсвөр насны 105 хүүхдүүдэд мэргэжлийн сургалт, нийгэм-сэтгэлзүйн цогц үйлчилгээг үзүүлсэн байна. Мөн хөтөлбөрийн хэтийн зорилго болох Монгол Улсад ял шийтгэлийн тогтолцооноос нөхөн сэргээх, эргэн нэгтгэлд суурилсан тогтолцоо руу шилжихэд дэмжлэг үзүүлэх, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтад шаардлагатай суурь судалгааны ажлыг амжилттай гүйцэтгэж дууслаа.

Түүнчлэн КНХС **Хүүхдийн Эрхийн Хууль Зүйн Хорооны гишүүнээр элссэн** явдал нь төрийн бус байгууллагын хувьд анхдагч болж, салбарын гол оролцогч талуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, өсвөр насныхны дуу хоолойг бодлогын түвшинд хүргэх боломжийг нэмэгдүүлж байна.



АМЖИЛТЫН ТҮҮХ

Саруулхүүгийн түүх: Боловсрол ба боломжоор ирээдүйгээ бүтээх нь

2022 онд Саруулхүү* Сургалт Хүмүүжлийн Тусгай Байгууллага (СХТБ)-д ирэхдээ уур бухимдал ихтэй, нийгмийн харилцаанаас тусгаарлагдсан, сурах хүсэлгүй байв. Тэрээр тусгай байгууллагад байгаа бусад хүүхдүүдийн нэгэн адил хүнд хэцүү нөхцөл, ядуурал, боломжоор дутмаг амьдралыг туулсан.

СХТБ нь өсвөр насныхныг сурган хүмүүжүүлэх төв (хуучнаар хорих төв) төдийгүй ерөнхий боловсролын сургуулийн үүргийг давхар гүйцэтгэдэг бөгөөд нөөцийн хязгаарлагдмал байдлаас үүдэлтэй өсвөр насныханд зориулсан хөгжлийн боломжоор дутмаг байдаг. Гэвч Кристина Ноблийн Хүүхдийн сан (КНХС) энэ орон зайг нөхөж хичээлээс гадуурх нэмэлт хөгжлийн хөтөлбөрүүдийг санал болгож, өсвөр насныхныг нийгэмд эргэн нэгтгэхэд нь дэмжлэг үзүүлж байна.



Саруулхүү нэг жилийн турш сургуулиасаа завсардсан тул хичээлдээ ихээхэн хоцрогдолтой байв. Гэвч тэрээр мэргэжлийн боловсрол олгох сургалт, англи хэл, хөгжим, уран зургийн хичээлд хамрагдсанаар өөрийн чадвар, боломжийг дахин нээж эхэлсэн юм. Цаг хугацааны явцад тэрээр зөвхөн хичээл сургуулиа нөхөөд зогсолгүй давсан амжилтыг гаргаж, түүхийн улсын олимпиадад 4-р байр эзэлж, англи хэлний анхан шатнаас дунд шатанд дэвшиж чаджээ. Түүний амжилт тусгай байгууллагын бусад хүүхдүүдэд ч урам зориг өгч чадсан юм.

2024 онд түүний хүчин чармайлт үр дүнгээ үзүүлж, их сургуулийн элсэлтийн ерөнхий шалгалтаа амжилттай өгч, Монгол Улсын Их Сургуульд тэнцжээ. Ингэснээр Саруулхүүд 2026 онд суллагдах хүртлээ их сургуулийн хичээлд цахимаар суралцах боломж бүрдсэн юм. Тэрээр шинэ боломжуудыг нээж эдгээр амжилтуудыг гаргахад тусалсан сургалт хүмүүжлийн тусгай байгууллага болон КНХС-ийн хамт олонд ихэд талархаж явдгаа хуваалцсан юм. Нэгэн цагт ирээдүйдээ итгэлгүй байсан тэрээр одоо боломж, итгэл найдвараар дүүрэн ирээдүйгээ бүтээж байна.

*Хувь хүний мэдээллийг нууцлах үүднээс нэрийг өөрчилсөн болно.
Энэхүү түүхийг хамтрагч байгууллага КНХС-аас хуваалцав.

СИСТЕМИЙН ТҮВШНИЙ ҮР НӨЛӨӨ

Монгол Улс дахь бага насны хүүхдийн хөгжлийн экосистемийг бэхжүүлэх

2022 онд НҮБ-ийн Хүүхдийн Сантай хамтран Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээг (МБНХХС) үүсгэн байгуулснаас хойш бид боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын 34 байгууллагыг нэгтгэх чухал үүргийг гүйцэтгэж байна. МБНХХ-ийн сүлжээ нь Монгол Улсад бага насны хүүхдийн хөгжлийн экосистемийн оролцогч талуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, тэдгээрийн чадавхыг бэхжүүлэх, бодлогын түвшний оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажилладаг. Гишүүд энэхүү сүлжээг салбар хоорондын уялдаа холбоог сайжруулж, сайн туршлагаа хуваалцан, бодлого боловсруулагч нартай хамтран ажиллахад гүүр болж буйг тодотгон онцолдог.

2024 онд бид дараах чиглэлд анхаарч ажиллалаа. Үүнд:

- Салбар хоорондын харилцан суралцах боломжийг нээж, хэрэгжүүлэгч байгууллагуудыг бодлого боловсруулагч нартай холбох;
- Гишүүдийн цар хүрээг тэлж, эрүүл мэндийн салбар, хувийн хэвшил, хөдөө орон нутгийн төрийн бус байгууллагуудын төлөөллийг хамруулах;
- Гишүүдийн судалгаа, үнэлгээ хийж, сүлжээний бүтцийг нарийвчлан тодорхойлох замаар засаглалыг бэхжүүлэх;


2024 оны хувьд Удирдах хороо болон Ажлын албыг томилсон нь сүлжээг “Тогтворжих үе”-рүү (2025-2026) шилжихэд нөлөөлөх чухал алхам байлаа.

СИСТЕМИЙН ТҮВШНИЙ ҮР НӨЛӨӨ

Үр дүнтэй шийдлүүдийг тэлж тогтолцооны өөрчлөлтийг бий болгох

Лоринэт Сангаас санхүүгийн дэмжлэг үзүүлдэг урт хугацааны төсөл хөтөлбөрүүд тогтолцоонд нэвтэрч, өргөн цар хүрээний тогтвортой өөрчлөлтийг бий болгох суурийг тавьж эхэллээ. Амжилттай хэрэгжсэн шийдлүүдийг тогтолцоонд нэвтрүүлснээр бодит хэрэгцээ шаардлагыг хангаад зогсохгүй урт хугацааны үр нөлөө бүхий бодлого, үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтой болж байна.

- **Дээд боловсрол ба хөдөлмөр эрхлэлт:** Зориг сан Монгол Улсын тэргүүлэх дээд боловсролын байгууллагатай хамтран ажиллаж олон мянган залууст карьер үйлчилгээг хүргэх боломжтой боллоо. Энэхүү загварыг амжилттай хэрэгжүүлснээр төрийн байгууллагын дэмжлэгтэйгээр улсын хэмжээнд бусад 62 их, дээд сургуулиудад нэвтрүүлэх боломжтой болох юм. Ингэснээр орон даяар оюутан залуусын боловсролоос хөдөлмөр эрхлэлт рүү шилжих үйл явцыг дэмжих томоохон өөрчлөлтийг авчирч чадах юм.
- **Өсвөр насныхныг нийгэмд эргэн нэгтгэх:** Кристина Ноблийн Хүүхдийн Сан нь гэмт хэрэгт холбогдсон өсвөр насныхан болон тэдэнд үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж бодлогын түвшинд өөрчлөлт авчрахыг зорьж байна. Олон талын хамтын ажиллагааг бий болгож, одоогийн тогтолцооны асуудлыг ил болгосноор ял шийтгэлээс боловсрол, нөхөн сэргээлтэд суурилсан тогтолцоонд шилжихэд хувь нэмрээ оруулахаар ажиллаж байна.



Үр дүнтэй шийдлүүдэд нэмэлт дэмжлэг бий болгох, сурталчлан таниулах

2024 онд бид дотоодын хувийн хэвшил, олон улсын санхүүжүүлэгч нартай харилцаа холбоогоо бэхжүүлж, Монголын нийгмийн тулгамдсан асуудлуудын талаар ойлголтыг нэмэгдүүлэх, үр дүнтэй төсөл хөтөлбөрүүдэд нэмэлт дэмжлэг бий болгоход чиглэн ажиллалаа. Эдгээр хүчин чармайлт оролцогч талуудын анхаарлыг татаж, цаашлаад зарим төсөл хөтөлбөрт бодит дэмжлэгийг бий болгож чадсан юм.

- Нийгмийн хариуцлагын хүрээнд стратегийн хөрөнгө оруулалт хийдэг БарлоВорлд ХХК Лоринэт сангийн зүгээс хэрэгжүүлсэн бага насны хүүхдийн хөгжлийн хөрөнгө оруулалтыг сурталчлах ажлыг өндрөөр үнэлэв. Бидний хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдтэй танилцах аялалд оролцож, Монгол дахь Америкийн Худалдааны Танхимын “Нийгмийн Хариуцлагын Шагнал”-аар үнэлэгдсэнд урамшин, бидний үндсэн төслүүдийн нэг болох **“Хамтдаа Уншицгаая” төслийг БарлоВорлд ХХК дэмжихээ мэдэгдсэн** нь томоохон амжилт байлаа.
- Бид уур амьсгалын өөрчлөлт нь хойч үед нөлөөлөх ноцтой, өргөн хүрээний асуудал хэмээн үзэж Дэ Нэйче Консерванси байгууллагын "Өнө мөнхийн Монгол" санаачилгад хөрөнгө оруулалт хийсэн билээ. Улмаар дутагдаж байсан санхүүжилтийг нөхөөд зогсохгүй олон улсын хандивлагчаас нэмэлт санхүүжилт босгоход чухал үүрэг гүйцэтгэж **Монголын хөгжил, сайн сайхан байдлыг дэмжихэд чиглэсэн нэмэлт эх үүсвэрийг бий болгож чадлаа.**

ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАНААС ХОЙШ

Олон улсад болон Монголд олгосон санхүүжилтээр нийт 54,674 хүн үр шим хүртжээ.

Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсрол

34,277

бага насны хүүхдийн чанартай асаргаа халамж, эрт үеийн боловсролд хамруулсан 0-5 настай хүүхдийн тоо

2,880

чадавхжуулах сургалтад хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчдын тоо

61%

ур чадвар нь нэмэгдсэн хэмээн мэдүүлсэн эцэг эх, асран хамгаалагчдын эзлэх хувь

2,054

чадавхжуулах сургалтад хамрагдсан бага насны хүүхдийн асаргаа халамж, эрт үеийн боловсролын үйлчилгээ үзүүлэгчдийн тоо

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт

3,995

хөдөлмөр эрхлэх болон өрхийн амьжиргаагаа дээшлүүлэхэд шаардлагатай ур чадваруудыг олгох сургалтад хамрагдсан залуучуудын тоо

79%

сургалтад хамрагдаад хөдөлмөр эрхлэлт рүү шилжсэн залуучуудын эзлэх хувь

80%

сургалтад хамрагдсанаар орлого эсвэл амьдралын чанар нь сайжирсан хэмээн мэдүүлсэн залуучуудын эзлэх хувь

222

ажиллах хүчний чадавхыг бэхжүүлэхэд хамтран ажилласан ажил олгогч, төрийн байгууллагын албан хаагчдын тоо



Лоринэт сан нь нийгмийн үр нөлөөлөө улам гүнзгийрүүлж, түншлэлээ бэхжүүлж, олон улсад Монголыг таниулан сурталчлах ажлыг тууштай хэрэгжүүлнэ.

Бид амжилттай хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийнхээ цар хүрээг тэлж, нотолгоо мэдлэгийг бий болгож, тогтвортой өөрчлөлтөд чиглэсэн стратегийн хамтын ажиллагааг үргэлжлүүлэх болно.

Монгол Улс руу чиглэсэн нийгмийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг нэмэгдүүлэх нь бидний тэргүүлэх чиглэл байж, улмаар Монгол Улсын хөгжлийн хэрэгцээ, боломжийг олон улсын санхүүжүүлэгчдэд таниулахад бидний үүрэг оролцоо чухал байр суурь эзэлнэ хэмээн үзэж байна. Түүнчлэн дотоодын хувийн хэвшлийн байгууллагуудтай урт хугацааны эерэг өөрчлөлт бий болгох зорилго бүхий нийгмийн хариуцлагын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд анхаарах болно.

Сангийнхаа Хяналт-үнэлгээ болон суралцахуйн арга зүй, чадамжаа улам гүнзгийрүүлэхээс гадна боловсрол, нийгмийн хөгжлийн бодлогын орчныг сайжруулах ажиллагааг улам бэхжүүлэхээр төлөвлөж байна.

Эдгээр хүчин чармайлтаар дамжуулан бид Монголын ирээдүй болох хүүхэд залуусын амьдралд эерэг үр нөлөө үзүүлээд зогсохгүй, урт хугацааны өөрчлөлтийг бий болгох шинэ боломжуудыг нээхийн төлөө хувь нэмрээ оруулан ажиллах болно.

Зураг: AmCham Mongolia

ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД



www.lorinetfoundation.org

© 2024 Лоринэт Сан
Холбоо барих: info@lorinetfoundation.org